



## БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.08.07 № 407  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд, аймгийн Төрийн аудитын газрын 2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу “Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан хүргүүлж байна.

Хавсралт *dd* хуудаатай

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ~~Б.ЭРДЭНЭ~~



006030490

БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН  
ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ

АУДИТЫН КОД: БУА-2023/25-4-ШТА-ГА

БУЛГАН АЙМАГ  
2023

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ  
Утас: 7034-2580 Цахим хаяг: [Erdeneb@audit.gov.mn](mailto:Erdeneb@audit.gov.mn)  
Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 7034-2716 Цахим хаяг: [Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)  
Ахлах аудитор: П.Содном  
Утас: 7034-2495 Цахим хаяг: [Sodnomp@audit.gov.mn](mailto:Sodnomp@audit.gov.mn)  
Аудитор: А.Сувдаа  
Утас: 7034-2495 Цахим хаяг: [Suvdaaa@audit.gov.mn](mailto:Suvdaaa@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах  
хаягаар авна уу: [bulgan@audit.gov.mn](mailto:bulgan@audit.gov.mn)



БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 4/14

Булган сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалт, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж”-д хийсэн шууд тайлагнах аудитын тайланг (БУА-2023/25-4-ШТА-ГА) баталсугай.


2.“Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж”-өөр илэрсэн алдаа, зөрчлийг нэг дүгээр хавсралтаар баталсугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнг 2023 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн дотор хариу ирүүлэхийг аймгийн ХХААГ-ын дарга (Ч.Амгалан)-д зөвлөсүгэй.

4.Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийн аудитын дүнг 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн дотор тооцож, танилцуулахыг ахлах аудитор (П.Содном), аудитын менежер (Ж.Энхцоодол) нарт үүрэг болгосугай.

5.Аудитын тайланг аймгийн ХХААГ, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газарт тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ



Агуулга

|   |    |
|---|----|
| <b>АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ</b> .....   | 5  |
| Ерөнхий мэдээлэл .....  | 7  |
| <b><i>А.1 Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээ нь хөдөө, аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой нийцэж байна уу.</i></b> .....   | 8  |
| <b>А.2 Хөдөө аж ахуйн салбараас хэрэгжүүлсэн төслөөс Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.</b> ..... | 8  |
| <b>А.2.1 Батлан даалтын сангаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс 2 аж ахуйн нэгж зээлийн гэрээнд заасан үндсэн болон хүүгийн эргэн төлөлт хийгдээгүйгээс хуулийн байгууллагад шилжсэн байна.</b> .....       | 8  |
| <b>А.2.2 Зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, хуулийн байгууллагад шилжсэн, эргэн төлөлт зогссон, хэрэгжиж байгаа төсөл нь бүрэн ашиглалтад ороогүй, зэрэг нь төслийн үр дүн хангалтгүй байна.</b> .....     | 9  |
| <b>Б. ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БУЙ ТАХ-НИЙ ХӨРӨНГИЙГ АШИГЛАЛТ ХЭВИЙН, ӨГӨӨЖТЭЙ БАЙНА.</b> .....  | 12 |
| <b>Б.1. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь салбарын бодлоготой уялдаж байна уу.</b> .....  | 12 |
| <b>Б.2 Булган аймагт 2 төслийн хүрээнд 246.1 сая төгрөгийн тусламж олгосон байна.</b> .....   | 12 |
| <b><i>Б.2.1 МААЭЗЭНТ, ХААХХТНС төслүүдийн хүрээнд тусламж олгосон байна.</i></b> .....  | 12 |
| <b><i>Б.2.2 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч нэгж нь орон нутагт байхгүй байна.</i></b> .....   | 14 |
| <b>В. ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ, ОРОН НУТАГТ ХЯНАЛТ ХИЙСЭН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ БАЙХГҮЙ БАЙНА.</b> .....   | 14 |
| <b><i>В.1 Зээл, тусламжийн хөрөнгийг олгох, хэрэгжүүлэх, ашиглах, хяналт тавих эрх зүйн орчин орон нутгийн салбар, харьяа байгууллагуудад дутмаг байна.</i></b> .....   | 14 |
| <b><i>В.1.1 Зээл, тусламжаар хэрэгжүүлсэн төслийн ил тод байдлыг Шилэн дансны тухай хуулиар Төрийн захиргааны төв байгууллага мэдээлэхээр байна.</i></b> .....  | 14 |
| <b>В.2 Зээл тусламжийн ашиглалтад дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцож байна уу.</b> .....  | 15 |
| <b>В.2.1 Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна уу.</b> .....   | 15 |

|  |    |
|--|----|
| <b>В.2.2 МААЭЗНТ болон ХААААТНСТ-ийн хүрээнд тусламжаар ирсэн 14 нэгж бүхий 75.2 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагууд бүртгэж, тайлагнасан байна.</b> ..... | 15 |
| ДҮГНЭЛТ .....  | 16 |
| ЗӨВЛӨМЖ.....   | 16 |
| САНАЛ.....   | 16 |

## Товчилсон үгийн тайлбар

|               |   |
|---------------|---|
| ААНБ          | Аж ахуй нэгж, байгууллага   |
| ЖДҮҮЭ         | Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх   |
| ЗБДТДЗЭЗТАБНТ | Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл |
| ЗДТГ          | Засаг даргын тамгын газар   |
| МАОЭЗЭНТ      | Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл  |
| МЭГ           | Мал эмнэлгийн газар   |
| МЭЕГ          | Мал эмнэлгийн ерөнхий газар   |
| ТАХ           | Төсөл арга хэмжээ   |
| ТХААТТНТ      | Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл   |
| ТХН           | Төсөл хэрэгжүүлэх нэгж  |
| ХААААТНСТ     | Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт төсөл   |
| ХХААГ         | Хүнс хөдөө аж ахуйн газар   |
| ХХААХҮЯ       | Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам   |
| ХААДС         | Хөдөө аж ахуйг дэмжих сан   |
| ХХК           | Хязгаарлагдмал хувьцаат компани   |
| ЯОУХАБ        | Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага   |

|  |                  |    |
|--|------------------|----|
| Хүснэгт № 1 ЗБДТДЗЭЗТАБНТ-ийн хүрээнд олгосон зээл                                 | /САЯ. ТӨГ/ ..... | 8  |
| Хүснэгт № 2 ТХААТТНТ-ийн эргэн төлөлтийн хуваарь .....                             |                  | 9  |
| Хүснэгт № 3 Гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл хөтөлбөр .....           |                  | 9  |
| Хүснэгт № 4 ЗБДТДЗЭЗТАБНТ-д хамрагдсан иргэн, ААНБ .....                           |                  | 10 |
| Хүснэгт № 5 ЗБДТДЗЭЗТАБНТ-д хамрагдсан иргэн, ААНБ-ын техник, тоног төхөөрөмж..... |                  | 11 |
| Хүснэгт № 6 Булган аймагт төслийн хүрээнд үзүүлсэн нийт тусламж .....              |                  | 12 |
| Хүснэгт № 7 МААЭЗЭНТ-өөс олгосон тэжээл (сумдаар).....                             |                  | 13 |
| Хүснэгт № 8 Гадаадын зээл, тусламжийн цахим хуудас.....                            |                  | 15 |
| Хүснэгт № 9 Гадаадын тусламжийн хүрээнд бүртгэлд тусгагдсан хөрөнгө.....           |                  | 16 |
| <br>   |                  |    |
| Хавсралт 1 Төслийн хүрээнд бүртгэгдсэн хөрөнгийн дэлгэрэнгүй жагсаалт              |                  | 17 |

## АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

|  |   |
|--|---|
| <p><b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b></p>     | <p>Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 09 дугаар тогтоолын хүрээнд хийлээ.</p>  |
| <p><b>Аудитын зорилт</b></p>                     | <p>“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулж дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Засгийн газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашиглаж байгаа эсэх</li> <li>• Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөжтэй байгаа эсэх</li> <li>• Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөөлтэй эсэх</li> </ul>                             |
| <p><b>Аудитын хамарсан хүрээ</b></p>             | <p>Аудитад Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, төслийн нэгж, холбогдох байгууллагын үйл ажиллагаа, 2016-2022 оны хугацаан дахь 9 төслийн хүрээнд хэрэгжсэн болон хэрэгжиж буй төсөл арга хэмжээний тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр дүнг аудитад хамрууллаа.</p>  |
| <p><b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b></p> | <p>Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-400, АДБОУС-3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, арга зүйг ашиглан ҮАГ-аас ирүүлсэн асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судалгаа, дүн шинжилгээ хийж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p> |

|                                     |  |
|-------------------------------------|--|
| <b>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</b> | <p>Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ хянан удирдаж, аудитын аудитын менежер Ж.Энхцоодол үе шатны чанарын хяналтыг хийж, ахлах аудитор П.Содном, аудитор А.Сувдаа нар хийж гүйцэтгэлээ.</p> <p>Аудитын урьдчилсан судалгааны үе шатны ажлыг 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс тус тус эхлэн, аудитын дэд төлөвлөгөөг 2023 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн дотор батлуулж, талбарын үе шатны ажлыг 2023 оны 06 дүгээр сарын 02-ний өдрөөс эхлэн гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 2023 оны 07 дугаар сарын 24-ны өдрөөс эхлүүлэн. Аудитын тайланг 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Үндэсний аудитын газарт болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ.</p> |
| <b>Хүндрэл бэрхшээл</b>             | <p>Хөдөө аж ахуйг дэмжих сангийн орон нутгийн салбарт тус зээлтэй холбоотой баримт материал, өглөг авлагын талаарх мэдээлэл байхгүй нь гэрээний хэрэгжилтийг аудитаар үзэх боломжгүй нөхцөл үүсэж байна.</p>   |

## Ерөнхий мэдээлэл

Булган аймагт Засгийн газрын шугамаар хөдөө аж ахуйн чиглэлээр 2016-2022 оны хугацаанд 5 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна.

| № | Төсөл хэрэгжүүлэгч байгууллага | Гадаадын зээл, буцалтгүй тусламж, техник тусалцааны төслийн  | ХӨРӨНГӨ, САНХҮҮЖИЛТ |   | Байршил, тайлбар  |  |
|---|--------------------------------|--|---------------------|---|---|--|
|   |                                | Нэр  | Төрөл               | Санхүүжүүлэгч байгууллага                   |   | Зориулалт  |
| 1 | ХХААХУ Яам                     | "Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл" /зээл/                                 | Зээл                | Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар | Бүгд Найрамдах Улсаас нийт 534 ширхэг техник, тоног төхөөрөмжийг Монгол Улсад нийлүүлэх                                   | Хутаг-Өндөр сум "Түмэн-Түрүү", Булган сумын иргэн С.Батбаяр нар зээлд хамрагдсан   |
| 2 | ХХААХУ Яам                     | Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох /зээл/ | Зээл                | Азийн Хөгжлийн Банк                         | Барьцаа хөрөнгийн дутагдалтай ЖДҮҮЭ нарт зээлийн 30-60 хувьд батлан даалт гаргах  | Булган аймагт 4 аж ахуйн нэгж зээл авсан "Түүчээ намнан" ХХК, "Уран онигууд" ХХК, "Их ураг", иргэн Б.Мөнхтөр                     |
| 3 | ХХААХУ Яам                     | "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт" төсөл /зээл/                               | Хөнгөлөлт тэй зээл  | Азийн хөгжлийн банк                         | Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжин, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулна   | Тус төслийн 2 ААНБ зөгийн гэр, сэмж олгосон, 2 суманд бэлчээрийн худаг гаргаж, 1200 малчин өрхөд хүнсний тусламж үзүүлсэн байна. |
| 4 | ХХААХУ Яам                     | Экспортыг дэмжих төсөл /зээл/  | Хөнгөлөлт тэй зээл  | Дэлхийн Банк, Олон улсын хөгжлийн ассоциаци | Уул уурхайн бус салбар дахь жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжийн экспортын зах зээлийг өргөжүүлэх                 | Булган аймагт Тэшиг суманд байршилтай "ИЛЭНХЭН" ХХК 42.9 сая төгрөгийн зээл авсан  |
| 5 | ХХААХУ Яам                     | Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл /зээл/  | Хөнгөлөлт тэй зээл  | Дэлхийн банк                                | Мал сүргийн эрүүл мэнд, бүтээмж, онцгой нөхцөл байдал, гамшгийн үед шуурхай, үр дүнтэй хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх. | Булган аймгийн Баяннуур Бугат, Бүрэгхангай, Дашинчилэн, Орхон, Рашаант, Сэлэнгэ, Хишиг-Өндөр,                                    |

Булган аймагт Засгийн газрын гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй 3 төсөл хөтөлбөрийн хүрээнд 1042.9 сая төгрөг, 67840 EUR, -гийн зээл олгосон, 2 төслийн хүрээнд 246.1 сая төгрөгийн тусламж олгосон байна.

**А. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БУЙ ТАХ НЬ БҮРЭН ДУУСААГҮЙ, ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЖ ҮР НӨЛӨӨГ ТООЦООСОН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ОРОН НУТАГТ ДУТМАГ УЧИР ЗЭЭЛИЙГ ҮР ДҮНТЭЙ АШИГЛАСАН ЭСЭХИЙГ ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.**

**А.1 Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээ нь хөдөө, аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой нийцэж байна уу.**

А.1.1 Гадаадын зээл тусламжаар санхүүжүүлж байгаа төсөл арга хэмжээг орон нутагт сонгон шалгаруулалт явуулдаггүй байна.

А.1.2. Тус зээлийн хүрээнд Булган аймагт эрх шилжин ирж орон нутгаас олгосон зээл байхгүй байна.

**А.2 Хөдөө аж ахуйн салбараас хэрэгжүүлсэн төслөөс Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.**

**А.2.1 Батлан даалтын сангаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс 2 аж ахуйн нэгж зээлийн гэрээнд заасан үндсэн болон хүүгийн эргэн төлөлт хийгдээгүйгээс хуулийн байгууллагад шилжсэн байна.**

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд Булган аймагт Төрийн банкнаас батлан даалтаар 3 аж ахуйн нэгж, 1 иргэнд 1,000.0 сая төгрөгийн зээл олгосон байна.

Хүснэгт № 1 ЗБДТДЗЭЗТАБНТ-ийн хүрээнд олгосон зээл

/сая. төг/

| №          | Хэрэгжүүлэгч        | Төслийн зориулалт   | Зээлийн хэмжээ /сая.төг | Олгосон батлан даалтын хэмжээ /сая.төг/ | Батлан даалтын хувь | Эхлэх | Дуусах |
|------------|---------------------|---|-------------------------|---|---------------------|-------|--------|
| 1          | “Түүчээ Намнан” ХХК | Махны зоорь ангилан боловсруулах үйлдвэр  | 500.0                   | 300.0                                   | 60%                 | 2020  | 2030   |
| 2          | “Их ураг” ХХК       | Бүрэн механикжсан гормын тохируулгатай ил зоорь барих                           | 250.0                   | 100.0                                   | 40%                 | 2018  | 2028   |
| 3          | Б.Мөнхтөр           | Үр тариа хураах тоног төхөөрөмж авах /Трактор, комбайн, үрлэгч, цэвэрлэгч ачигч | 100.0                   | 50.0                                    | 50%                 | 2019  | 2029   |
| 4          | “Уран онигууд” ХХК  | Төмс, тариалах.   | 150.0                   | 90.0                                    | 60%                 | 2021  | 2024   |
| <b>Дүн</b> |                     |   | 1,000.0                 | 540.0                                   | -                   | -     | -      |

“Түүчээ Намнан” ХХК, “Уран онигууд” ХХК-иуд 650.0 сая төгрөгийн зээл нь зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээнд тусгасан үндсэн болон хүүгийн эргэн төлөлт хийгдээгүй, зогсож зээлдэгч шүүхэд шилжүүлж, шүүхийн шийдвэр гарсан байна.

**“Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл”** Беларус улсын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлсэн техник тоног

төхөөрөмжийн зээлийг Сангийн яам, ХХААХҮЯ-тай эцсийн зээлдэгчээр “Хөдөө аж ахуйг дэмжих сан”-гаар дамжуулан зээл олгохоор гэрээг байгуулжээ.

**Хүснэгт № 2 ТХААТНТ-ийн эргэн төлөлтийн хуваарь**

| Харилцагчийн нэр  | Аймаг  | Сум         | Гэрээ байгуулсан огноо | Гэрээний дагуу эргэн төлөлтийн хуваарь |         | Эргэн төлөлт /евро/ | Тайлбар                     |
|-------------------|--------|-------------|------------------------|--|---------|---------------------|-----------------------------|
| “Түмэн түрүү” ХХК | Булган | Хутаг-Өндөр | 2021.09.06             | 2022                                   | 8239.96 | 0                   | Эргэн төлөлт хийгдээгүй.    |
|                   |        |             |                        | 2023                                   | 8131.53 | 0                   | Хугацаа болоогүй            |
|                   |        |             |                        | 2024                                   | 8023.1  | 0                   | Хугацаа болоогүй            |
| С.Батбаяр         | Булган | Булган      | 2021.09.13             | 2022                                   | 8239.96 | 12050.99            | Зээлийн эргэн төлөлт хэвийн |
|                   |        |             |                        | 2023                                   | 8131.53 | 0                   | Хугацаа болоогүй            |
|                   |        |             |                        | 2024                                   | 8023.1  | 0                   | Хугацаа болоогүй            |

Дээрх 2 зээлдэгчээс “Түмэн түрүү” ХХК нь гэрээний 1-р хавсралтад заасан төлбөр барагдуулах графикийн дагуу эргэн төлөлт хийгдээгүй, гэрээний хэрэгжилт хангаж ажиллаагүй байна.

Хөдөө аж ахуйг дэмжих сангийн орон нутгийн салбарт тус зээлтэй холбоотой баримт материал, өглөг авлагын талаарх мэдээлэл байхгүй нь гэрээний хэрэгжилтийг аудитаар үзэх боломжгүй байна.

**А.2.2 Зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, хуулийн байгууллагад шилжсэн, эргэн төлөлт зогссон, хэрэгжиж байгаа төсөл нь бүрэн ашиглалтад ороогүй, зэрэг нь төслийн үр дүн хангалтгүй байна.**

Булган аймагт Засгийн газрын гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй 3 төсөл хөтөлбөрийн хүрээнд 1042.9 сая төгрөг, 67840 EUR, -гийн зээл олгосон байна.

**Хүснэгт № 3 Гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл хөтөлбөр**

| № | Төсөл хөтөлбөрийн нэр   | Ашиглагчийн нэр     | Мөнгөн дүн    |       |
|---|---|---------------------|---------------|-------|
|   |   |                     | MNT /сая.төг/ | EUR   |
| 1 | Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл | “Түүчээ Намнан” ХХК | 500.0         |       |
|   |   | “Их ураг” ХХК       | 250.0         |       |
|   |   | Б.Мөнхтөр           | 100.0         |       |
|   |   | “Уран онигууд” ХХК  | 150.0         |       |
| 2 | Экспортыг дэмжих төсөл  | “Илэнхэн” ХХК       | 42.9          |       |
| 3 | Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл   | “Түмэн түрүү” ХХК   |               | 33920 |
|   |   | С.Батбаяр           |               | 33920 |

*Эх сурвалж: Зээлийн гэрээ*

Дээрхээс үзвэл “Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд 3 иргэн, ААНБ 1,000.0 сая төгрөг, “Экспортыг дэмжих” төслөөр Тэшиг суманд байршилтай “Илэнхэн” ХХК 42.9 сая төгрөг, “Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх” төслөөс 2 аж ахуйн нэгж тус бүр 33920 EUR-ийн зээл авсан байна.

**“Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл”** Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д “банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах”-аар заасан байдаг.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл”-өөр Төрийн банкаар олгосон 4 зээлээс газар тариалангийн техник тоног төхөөрөмж авах 1 иргэний 100.0 сая төгрөгийн зээл зориулалтын дагуу зарцуулсан, 1 аж ахуйн нэгжийн хэрэгжүүлсэн төсөл нь бүрэн ашиглалтад ороогүй, 2 аж ахуйн нэгж нь тус зээлийн эргэн төлөлт хийгдээгүй үйл ажиллагаа зогссон шүүхийн шийдвэр гарч ажиллагаа хийгдэж байна.

Хүснэгт № 4 ЗБДТДЗЭЗТАБНТ-д хамрагдсан иргэн, ААНБ

| № | Хэрэгжүүлэгч        | Төслийн зориулалт   | Зээлийн хэмжээ /сая.төг/ | Эхлэх он | Дуусах он | Зээлийн ашиглалт /Тайлбар /  |
|---|---------------------|---|--------------------------|----------|-----------|--|
| 1 | “Түүчээ Намнан” ХХК | Махны зоорь ангилан боловсруулах үйлдвэр  | 500.0                    | 2020     | 2030      | Зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй, үйл ажиллагаа зогссон, зээлийн эргэн төлөлт хийгдээгүй шүүхийн шийдвэр гарч ажиллагаа хийгдэж байна. |
| 2 | “Их ураг” ХХК       | Бүрэн механикжсан гормын тохируулгатай ил зоорь барих   | 250.0                    | 2018     | 2028      | Ил зоорины барилга барьсан, тоног төхөөрөмж суурилуулаагүй, үйл ажиллагаа эхлээгүй,  |
| 3 | Б.Мөнхтөр           | Үр тариа хураах тоног төхөөрөмж авах /Трактор, комбайн, үрлэгч, цэвэрлэгч ачигч Төмс, тариалах. | 100.0                    | 2019     | 2029      | Зээлийг зориулалтын дагуу ашиглан, үйл ажиллагаа хэвийн явж байгаа.  |
| 4 | “Уран онигууд” ХХК  |   | 150.0                    | 2021     | 2024      | Зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй, үйл ажиллагаа зогссон, зээлийн эргэн төлөлт хийгдээгүй шүүхийн шийдвэр гарч ажиллагаа хийгдэж байна. |
|   | Дүн                 |   | 1000.0                   | -        | -         |  |

Дээрх 4 ТАХ-ээс төслийн баримт бичиг, зориулалтын дагуу хэрэгжиж буй 2 ТАХ, зээлийг зориулалтын бус ашигласан, гэрээнд заасан эргэн төлөлт зогсож хуулийн байгууллагад шилжүүлэн шийдвэр гарч ажиллагаа хийгдэж байгаа 2 ТАХ байна.

Дээрх 1 иргэн нь Тэшиг суманд газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн зээлийг зориулалтын дагуу зарцуулж техник тоног төхөөрөмж худалдан авч 60 га тариалалт хийсэн байна.

**“Их ураг” ХХК-нь** бүрэн механикжсан горимын тохируулгатай ил зоорь барихаар 2018 онд зээл авсан. Хуучин барилгын суурь худалдан авч засварлан 3 тасалгаатай /10\*30 / харьцаатай барилга барьсан, мөн ажилчдын барилга 80 хувийн гүйцэтгэлтэй

хөргүүрийн тоног төхөөрөмжийн худалдан авалт хийгдээгүй санхүүжилт дутагдалтай зогсоон тус төсөл арга хэмжээ нь 4 жилийн хугацаанд ашиглалт ороогүй, үйл ажиллагаа явуулаагүй байна.

Харин дээрх аж ахуйн нэгжүүдээс “Түүчээ Намнан” ХХК, “Уран онигууд” ХХК-нууд 650.0 сая төгрөгийн зээл нь зориулалтын дагуу зарцуулаагүй, үндсэн болон хүүгийн эргэн төлөлт зогсож зээлдүүлэгч гэрээний дагуу шүүхэд шилжүүлж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа талаар албан бичгийг Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 2023.07.20-ны өдрийн 02/607 тоот албан бичиг ирүүлсэн.

**“Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл”** Беларус улсын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлсэн техник тоног төхөөрөмжийн зээлийг Сангийн яам, ХХААХҮЯ-тай эцсийн зээлдэгчээр “Хөдөө аж ахуйг дэмжих сан”-гаар дамжуулан зээл олгохоор гэрээг байгуулжээ.

Тус зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн жагсаалтад Булган аймгаас С.Батбаяр, “Түмэн түрүү” ХХК” гэсэн 2 зээлдэгч нь тус бүр 33920 еврогийн үнэ бүхий 4 төрлийн техник авсан байна.

*Хүснэгт № 5 ЗБДТДЗЭЗТАБНТ-д хамрагдсан иргэн, ААНБ-ын техник, тоног төхөөрөмж*

| Харилцагчийн нэр  | Аймаг  | Сум         | Бүтээгдэхүүний нэр            | Нийт төлбөр, евро |
|-------------------|--------|-------------|-------------------------------|-------------------|
| “Түмэн түрүү” ХХК | Булган | Хутаг-Өндөр | Беларусь-82.1                 | 16,570.00         |
|                   |        |             | Хадуур КДН-210                | 3,100.00          |
|                   |        |             | Тармуур ГВР-630               | 4,450.00          |
|                   |        |             | Дөрвөлжин хаман боогч ППТ 160 | 9,800.00          |
| С.Батбаяр         | Булган | Булган      | Беларусь-82.1                 | 16,570.00         |
|                   |        |             | Хадуур КДН-210                | 3,100.00          |
|                   |        |             | Тармуур ГВР-630               | 4,450.00          |
|                   |        |             | Дөрвөлжин хаман боогч ППТ 160 | 9,800.00          |

“Түмэн түрүү” ХХК нь тус зээлээр авсан беларусь-82, хадлангийн иж бүрдэл ашиглаж байгаа бөгөөд 2022 онд 20 га талбайд ногоон тэжээл тариалж 72 тн хураан авсан, 2023 онд 93 талбайд тэжээлийн ургамал тариалсан байна.

Харин иргэн С.Батбаяр нь Булган аймагт хадлан, тэжээл бэлтгэсэн талаарх статистик мэдээ, мэдээлэл байхгүй, техник тоног төхөөрөмж нь орон нутагт байдаггүй байна. Зээлдэгчээс тодруулахад авсан техник тоног төхөөрөмж нь Сэлэнгэ аймгийн Цагааннуур суманд байдаг 2021 оны 10 сард техник хүлээн авсан цаг хугацаа оройтсон тул үйл ажиллагаа явуулаагүй, 2022 онд Сэлэнгэ аймгийн Цагааннуур суманд хадлан бэлтгэсэн гэх боловч нотлох баримт байхгүй байна.

Дээрх иргэн, ААНБ-ийн зээлийн талаарх мэдээллийг ирүүлэхийг Хөдөө аж ахуйг дэмжих сангийн орон нутгийн салбарт хүргүүлсэн боловч тус зээлтэй холбоотой баримт материал, өглөг авлагын талаарх мэдээлэл салбарт байхгүй байна.

**“Экспортыг дэмжих төсөл”** Монгол Улсын уул уурхайн бус салбарын жижиг, дунд аж ахуйн нэгжийн экспортын чадамжийг сайжруулах, экспортын зах зээлээ тэлэх болон экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилготой уг төсөлд Булган

аймгаас “Илэнхэн” ХХК нь 2023 онд 42.9 сая төгрөгийн зээлийг малын тэжээл үйлдвэрлэхээр авсан байна.

“Илэнхэн” ХХК нь зээл авснаас хойш Булган аймгийн Тэшиг сумын Далан багт нийт 70 га газарт овьёос, улаан буудай, бог будаа, арвай хольж тарьсан 4 хүнийг байнгын, 20-30 хүнийг түр ажлын байраар хангаж, 2023 оны тариалалт хийсэн байна.

Тус төслийн талаар аймгийн ХХААГ-т мэдээлэл ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлсэн ч “Экспортыг дэмжих” төсөл нь 2022 оноос ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрлэлийн газартай хамтран төсөл хэрэгжүүлж эхэлсэн учир манай байгууллагаас мэдээлэл гарах боломжгүй гэсэн хариуг ирүүлсэн.

## **Б.ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БУЙ ТАХ-НИЙ ХӨРӨНГИЙГ АШИГЛАЛТ ХЭВИЙН, ӨГӨӨЖТЭЙ БАЙНА**

### **Б.1. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь салбарын бодлоготой уялдаж байна уу.**

Хамааралгүй

Б.1.1 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь урт, дунд, богино хугацааны бодлогыг дэмжиж байна уу.

Хамааралгүй

Б.1.2 Тусламж нь олон нийт, нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хангаж байна уу.

Хамааралгүй

Б.1.3 Тусламжийн хөрөнгийг сонгох, үнэлэх, эрэмбэлэх ажил хийгдэж, шаардлагатай төсөл, арга хэмжээг хамруулсан уу

Хамааралгүй

### **Б.2 Булган аймагт 2 төслийн хүрээнд 246.1 сая төгрөгийн тусламж олгосон байна.**

#### **Б.2.1 МААЭЗЭНТ, ХААХХТНС төслүүдийн хүрээнд тусламж олгосон байна.**

ХХААХҮЯ-аас хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн хүрээнд Булган аймагт дараах тусламжийг үзүүлсэн байна.

*Хүснэгт № 6 Булган аймагт төслийн хүрээнд үзүүлсэн нийт тусламж*

| № | Төслийн нэр            | Хамрагдсан ААНБ, иргэн | Зориулалт /тоо хэмжээ/ |              |               | Зарцуулсан төсөв /сая.төг/ |
|---|------------------------|------------------------|------------------------|--------------|---------------|----------------------------|
|   |                        |                        | Сургалт                | Хөрөнгө      | Тэжээл        |                            |
| 1 | МААЭЗЭНТ               | МЭГ                    |                        | 12           |               | 28.43                      |
|   |                        | Малчид /101/           |                        |              | 24000         | 27.05                      |
|   |                        | Малын эмч нар, малчид  | 579                    |              |               | 12.12                      |
| 2 | ХААХХТНС               | "Сүргийн нуга"ХХК      |                        | 89           |               | 16.94                      |
|   |                        | "Зөгийн баялаг" хоршоо |                        | 68           |               | 13.02                      |
|   |                        | Сайхан сумын ЗДТГ      |                        | 1            |               | 23.70                      |
|   |                        | Гурванбулаг сумын ЗДТГ |                        | 1            |               | 24.90                      |
|   |                        | Малчид /1200-хүнс/     |                        |              |               | 96.97                      |
|   | Тусламжид хамрагдагчид | 60                     |                        |              | 3.03          |                            |
|   | <b>Нийт</b>            | <b>639</b>             | <b>171</b>             | <b>24000</b> | <b>246.16</b> |                            |

Эх сурвалж: УАГ-аас ирүүлсэн төслүүдийн дэлгэрэнгүй жагсаалтаас

**“Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”**- өөс Булган аймгийн отроор явж байсан малчдад нийт 24.0 тн тэжээлийг Засгийн газрын 2020 оны 213 дугаар “Өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор, мал эмнэлгийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, цаг үеийн мэдээллийг түргэн шуурхай солилцох чадавхыг сайжруулах тоног төхөөрөмжийг МЭЭГ-аар дамжуулан 12 тооны 28.4 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн МЭГ-т санхүүжүүлэн олгосон байна.

Хүснэгт № 7 МААЭЗЭНТ-өөс олгосон тэжээл (сумдаар)

| № | Сум         | Хамрагдсан малчдын тоо | Тоо /шуудайгаар/ | Хэмжээ /кг-аар/ | Олголтын огноо |
|---|-------------|------------------------|------------------|-----------------|----------------|
| 1 | Баяннуур    | 21                     | 125              | 5,000           | 1/21/2021      |
| 2 | Бүрэгхангай | 9                      | 50               | 2,000           | 3/9/2021       |
| 3 | Гурванбулаг | 21                     | 125              | 5,000           | 2/27/2021      |
| 4 | Дашинчилэн  | 21                     | 125              | 5,000           |                |
| 5 | Рашаант сум | 21                     | 125              | 5,000           | 1/21/2021      |
| 6 | Хишиг-Өндөр | 8                      | 50               | 2,000           | 3/31/2021      |
|   | Нийт        | 101                    | 600              | 24,000          |                |

Эх сурвалж: Аймгийн ХХААГ-ын 2023 оны 1/185 тоот албан бичиг, хавсралтаас

Аймгийн МЭГ-аас ирүүлсэн мэдээллээр “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд 2022 онд Лабораторийн бизнес менежмент сургалт, “Мал эмнэлгийн лабораторийн хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, хэмжлийн эргэлзээг үнэлэх гурван хоногийн сургалтад, 2023 онд “Лабораторийн био аюулгүй байдал, эрсдэлийн үнэлгээ” сургалтад тус тус 2 ажилтан, албан хаагч хамрагдсан байна.

Төслийн албан ёсны цахим <http://lcp.mn/>, <https://www.facebook.com/lcpmongolia>, <https://www.facebook.com/vet.continuestraining> сайтад мэдээлснээр 2022 онд Мал эмнэлгийн лабораторийн хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, хэмжлийн эргэлзээг үнэлэх ажлын байрны сургалт, 2023 онд МАА-н ЭЗЭН төслийн “Малын эрүүл мэндийн үйлчилгээг бэхжүүлэх” бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Мал эмнэлгийн байгууллагын болон хүний нөөцийг чадавхжуулахад, “Мал эмнэлгийн хүний нөөцийн хөгжил, удирдлагын системийг орон нутагт нэвтрүүлэх мэргэжилтэн бэлтгэх сургалт”-д 21 аймгаас хамрагдсан бөгөөд Төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалтад МЭ-ийн маркетинг, лабораторийн менежмент, бог малын мялзан, шүлхий өвчний талаар 49 малын эмч хамрагджээ.

Малын эрүүл мэндийн суурь мэдлэг олгох сургалтад 8 сумын 560 малчныг хамруулж 5.6 сая төгрөгийг зарцуулсан талаар ҮАГ-аас ирүүлсэн судалгаа мэдээлэлд байгаа боловч ямар сургалтын байгууллага хэзээ хаана сургалт явуулсан талаар орон нутагт тодорхой мэдээлэл, баримт материал байхгүй учир аудитад хамрагдаагүй болно.

**“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт”** төслийн хүрээнд 2019 онд Хангал сумын Хялганат тосгоны “Сүргийн нуга” ХХК, Сэлэнгэ сумын “Зөгийн баялаг” хоршоонд нийт 136 тооны 25.3 сая төгрөгийн зөгийн гэр, 21 тооны 4.7 сая төгрөгийн зөгийн сэмж, 2020 онд Сайхан сумын Мануулт багийн Бүрдний

эхэд 23.7 сая төгрөгийн, Гурванбулаг сумын Бэрх багийн Цагаан чулуудад 24.9 сая төгрөгийн худгийг шинээр барьж байгуулсан байна.

Төсөлд хамрагдсан Хангал сумын Хялганат тосгоны “Сүргийн нуга” ХХК, Сэлэнгэ сумын “Зөгийн баялаг” ХХК нь 2020-2022 онд 35-45 бүл зөгийнөөс 200-300л бал хураан авч зах зээлд борлуулж үйл ажиллагаа хэвийн явуулж байна.



Мөн төслийн хүрээнд өвөлжилт хүндэрсэн аймгуудын малчин өрхөд олгох хүнсний тусламжийг аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/105 захирамжаар 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан 7 сумын 1200 өрхөд 96.7 сая төгрөгийн тусламжийг олгосон байна.

Тус төслийн хүрээнд 60 хүнийг сургалтад хамруулж 3.03 сая төгрөгийг зарцуулсан талаарх тодорхой мэдээлэл байхгүй учир аудитад хамрагдаагүй болно.

### ***Б.2.2 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч нэгж нь орон нутагт байхгүй байна.***

Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 24.3, 24.5, 25.1.1- 25.1.3-д зааснаар төслийг дуусгавар болсонд тооцож тайлан мэдээг холбогдох газруудад хүргүүлж, 25.3-25.7-д ТХН үр нөлөөг тооцохоор заасан байна.

## **В. ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ, ОРОН НУТАГТ ХЯНАЛТ ХИЙСЭН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ БАЙХГҮЙ БАЙНА.**

### ***В.1 Зээл, тусламжийн хөрөнгийг олгох, хэрэгжүүлэх, ашиглах, хяналт тавих эрх зүйн орчин орон нутгийн салбар, харьяа байгууллагуудад дутмаг байна.***

#### ***В.1.1 Зээл, тусламжаар хэрэгжүүлсэн төслийн ил тод байдлыг Шилэн дансны тухай хуулиар Төрийн захиргааны төв байгууллага мэдээлэхээр байна.***

Зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн 6.5<sup>1</sup>, 7.1.1<sup>2</sup>-д болон Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын 9.1<sup>3</sup>-т заасны дагуу ТХН мэдээлэхээр заасан байна.

Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийг хэрэгжүүлэгч нэгжүүд ил тод байдлыг хангах үүднээс дараах цахим сайтуудаар мэдээллээ иргэд, олон нийт,

<sup>1</sup> Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг гаргана

<sup>2</sup> Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан

<sup>3</sup> Төсөл хэрэгжүүлэгч байгууллага дараах чиг үүрэгтэй

ААНБ-уудад хүргэж байна. Тухайлбал: Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслүүдийн Удирдлагын мэдээллийн систем <https://odamis.mof.gov.mn/> цахим хуудсанд байршуулж байна.

*Хүснэгт № 8 Гадаадын зээл, тусламжийн цахим хуудас*

| № | Төслийн нэр  | Албан ёсны цахим хуудас   | Facebook фээж хуудас  |
|---|--|---|---|
| 1 | Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох /зээл/ | <a href="https://cgf.mn/adb-guarantee/">https://cgf.mn/adb-guarantee/</a> |   |
| 2 | Экспортыг дэмжих төсөл /зээл/  | <a href="http://www.edp.mn">www.edp.mn</a>                                | <a href="https://www.facebook.com/ExportDevelopmentProject">https://www.facebook.com/ExportDevelopmentProject</a>             |
| 3 | Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл / зээл/   | <a href="http://www.Lcp.mn">www.Lcp.mn</a>                                | <a href="https://www.facebook.com/lcpmongolia">https://www.facebook.com/lcpmongolia</a>                                       |
| 4 | Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил /Нэмэлт санхүүжилт/ зээл  | <a href="http://www.pmpmd.mm">www.pmpmd.mm</a>                            | <a href="https://www.facebook.com/profile.php?id=100069609001584">https://www.facebook.com/profile.php?id=100069609001584</a> |
| 5 | “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” /зээл, буцалтгүй тусламж/                       |   | <a href="https://www.facebook.com/profile.php?id=100064109016404">https://www.facebook.com/profile.php?id=100064109016404</a> |

Түүнчлэн аймгийн ХХААГ албан ёсны цахим хуудас <https://bulgan.hhaag.gov.mn/> болон <https://www.facebook.com/hhaag.bulganaimag> фээж хуудсаар төслийн зарим мэдээллийг байршуулж ажилласан байна.

***В.1.2 Булган аймагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрт хяналт шалгалт хийсэн тухай мэдээлэл, баримт материал байхгүй байна.***

Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл арга хэмжээнүүд талаарх мэдээллийг ирүүлэхийг аймгийн ЗДТГ, ХХААГ, ХААДС зэрэг байгууллагад хүргүүлсэн боловч энэ талаарх тодорхой мэдээлэл байхгүй байна.

Булган аймагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрт эрх бүхий байгууллагуудаас хяналт шалгалт хийсэн тухай мэдээллийг, баримт материал ирүүлээгүй болно.

***В.2 Зээл тусламжийн ашиглалтад дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцож байна уу.***

В.2.1 Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна уу.

Хамааралгүй.

***В.2.2 МААЭЗНТ болон ХААААТНСТ-ийн хүрээнд тусламжаар ирсэн 14 нэгж бүхий 75.2 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагууд бүртгэж, тайлагнасан байна.***

“Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд мал эмнэлгийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, цаг үеийн мэдээллийг түргэн шуурхай солилцох чадавхыг сайжруулах тоног төхөөрөмжийг МЭЭГ-аас 12 тооны 28.4 сая төгрөгийн хөрөнгийг /дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харах/ аймгийн МЭГ 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр, “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслөөс тус аймгийн Сайхан, Гурванбулаг суманд инженерийн хийцтэй нийт 48.6 сая төгрөгийн 2 худгийг барьж өгснийг Гурванбулаг сумын ЗДТГ 2022 онд, Сайхан сумын ЗДТГ-т 2022 онд тус тус орлого авч Засгийн газрын 2016 оны 176 дугаар

тогтоолоор баталсан "Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах" журмын 25.6<sup>4</sup>-д заасны дагуу төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэж тайлагнасан байна.

**Хүснэгт № 9 Гадаадын тусламжийн хүрээнд бүртгэлд тусгагдсан хөрөнгө**

| №           | Төслийн нэр | Хөрөнгийн ерөнхий нэр | Мөнгөн дүн | Тоо, хэмжээ | Орлого авсан байгууллага | Орлого авсан огноо |
|-------------|-------------|-----------------------|------------|-------------|--------------------------|--------------------|
| 1           | МЭЭЗЭНТ     | Тоног төхөөрөмж       | 28.4       | 12          | аймгийн МЭГ              | 6/30/2022          |
| 2           | ХААХХТНС    | Худаг                 | 23.4       | 1           | Сайхан сумын ЗДТГ        | 2022               |
|             |             | Худаг                 | 23.4       | 1           | Гурванбулаг сумын ЗДТГ   | 2022/10 сар        |
| <b>Нийт</b> |             |                       | 75.2       | 14.0        |                          |                    |

Эх сурвалж: МЭГ-ийн 2023 оны 01/176, Гурванбулаг сумын 02/341 тоот албан бичиг

Холбогдох мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа, хяналт сулаас тусламжаар ирсэн хөрөнгө, тоног төхөөрөмжийг холбогдох байгууллага орлогоор бүртгэхгүй орхих, хугацааны хувьд хожуу бүртгэлд тусгах эрсдэлтэй байна.

**ДҮГНЭЛТ:** Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн ашиглалт, хэрэгжилтэд эрх бүхий байгууллагын хяналт хийгдээгүй;
- ТХН болон ХХААХҮЯ орон нутгийн ХХААГ-тай мэдээлэл солилцох, түгээх хамтын ажиллагаа, хяналт сул;
- Гадаадын зээл, тусламжийн хүрээнд ирсэн хөрөнгө, хийгдсэн сургалт, зээлийн мэдээлэл, судалгаа орон нутагт байхгүй;
- Тусламжийн хүрээнд ирсэн хөрөнгө, тоног төхөөрөмжийг холбогдох байгууллага орлогоор бүртгэхгүй орхих, хожуу бүртгэлд тусгах зэрэг эрсдэлтэй байна.

**ЗӨВЛӨМЖ: АЙМГИЙН ХХААГ-ЫН ДАРГА Ч.АМГАЛАНД**

- Гадаад зээл, тусламжийн төслөөр орон нутагт хэрэгжиж байгаа зээл, сургалт, тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл, судалгааг дээд шатны байгууллагаас авч орон нутгийн удирдах байгууллагыг мэдээллээр цаг алдалгүй хангаж ажиллах

**САНАЛ: ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

1. Төслийн хүрээнд хэрэгжих арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн оролцоог хангах, санал авах ажлыг зохион байгуулах зөвлөмжийг ТХН болон ХХААХҮЯ-д,
2. ТХН болон ХХААХҮЯ орон нутгийн ХХААГ-тай мэдээлэл солилцох, түгээх хамтын ажиллагаа, хяналтыг сайжруулах зөвлөмжийг ХХААХҮЯ-д,
3. Төслийн хүрээн хэрэгжүүлсэн арга хэмжээ, гүйцэтгэлийг аймгийн ХХААГ-т судалгаагаар тогтмол хүргүүлж байх зөвлөмжийг ТХН-д,
4. Аймгийн ХХААГ төслийн хүрээнд хийгдсэн арга хэмжээ, гүйцэтгэлд тодорхой давтамжтайгаар хяналтыг хэрэгжүүлж ХХААХҮЯ-д үр дүнг танилцуулах зөвлөмжийг ХХААХҮЯ-д тус тус хүргүүлэх саналтай байна.

<sup>4</sup> ТХН нь төслийн эцсийн тайланг гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан "Төслийн эцсийн тайлангийн загвар" маягтын дагуу боловсруулж, санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулан холбогдох байгууллагуудад хүргүүлж, Удирдлагын мэдээллийн системд оруулах бөгөөд төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгүүлнэ.

## Хавсралт 1. Төслийн хүрээнд бүртгэгдсэн хөрөнгийн дэлгэрэнгүй жагсаалт

| /мянган төгрөгөөр/ |  |             |             |              |                  |
|--------------------|--|-------------|-------------|--------------|------------------|
| №                  | Хөрөнгийн нэр                              | Хэмжих нэгж | Нэгжийн үнэ | Тоо, хэмжээ  | Нийт үнэ         |
| 1                  | Ширээ сандал                               | ш           | 1,243.00    | 1            | 1,243.00         |
| 2                  | Чанга яригчтай микрофон                    | ш           | 422.40      | 1            | 422.40           |
| 3                  | Видео хурлын камер                         | ш           | 1,007.12    | 1            | 1,007.12         |
| 4                  | Зурагт 55, босоо хөл                       | ш           | 2,600.00    | 1            | 2,600.00         |
| 5                  | Хяналтын камер                             | ш           | 321.17      | 2            | 642.33           |
| 6                  | Халдваргүйтгэлийн тоног төхөөрөмж /шүрших/ | ш           | 2,514.07    | 1            | 2,514.07         |
| 7                  | Зөөврийн ламп                              | ш           | 2,451.69    | 1            | 2,451.69         |
| 8                  | Дрон                                       | ш           | 7,983.53    | 1            | 7,983.53         |
| 9                  | Компьютер                                  | ш           | 3,877.08    | 1            | 3,877.08         |
| 10                 | Принтер                                    | ш           | 1,761.79    | 1            | 1,761.79         |
| 11                 | Хөргөгч т/т                                | ш           | 3,924.61    | 1            | 3,924.61         |
| <b>Нийт</b>        |  |             |             | <b>12.00</b> | <b>28,427.63</b> |

Эх сурвалж: МЭГ-ийн 2023 оны 01/176 тоот, хавсралтаас